



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/251

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр өргөтгөсөн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн хэмжээнд хаваржилт хүндэрч Онцгой комиссын шийдвэрийн дагуу Төгрөг, Баруунбаян-Улаан сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцдөө дахин татан авсан өвс, ногоон тэжээл тутамд 7000 төгрөгийн үнийн дэмжлэг, Богд сумын аюулгүйн нөөцдөд 500 боодол өвс нэмж олгосон, нийт 21,145,000 (хорин нэгэн сая нэг зуун дөчин таван мянга) төгрөгийн зардлыг 1 дүгээр, Нарийнтээл суман дахь Улсын нөөцийн цэгээс Хархорин сумын өвс, тэжээлийн нөөцдөд олгосон хивэгний үнэ 3,432,640 (гурван сая дөрвөн зуун гучин хоёр мянга зургаан зуун дөч) төгрөгийн зардлыг 2 дугаар, Өмнөговь аймгийн Өлзийт Хөсөг ХХК-иас хандивласан 5 тонн цагаан будааг татан авах тээврийн хөлс 500,000 (таван зуун мянга) төгрөгийн зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 25,077,640 (хорин таван сая далан долоон мянга зургаан зуун дөч) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлыг зохион байгуулж, өвс, ногоон тэжээл нийлүүлсэн иргэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, татан авах ажлыг шуурхай явуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН



Q224 11 0520